



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор аймгийн Хүүхдийн Тэмүжин театрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/48/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2020 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576                      Цахим хаяг: Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140      Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn  Аудитор: М.Алтантуяа Утас:99061861                      Цахим хаяг:</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Аудитын гэрчилгээ .....	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил .....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	8
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	8
2.13. Шилэн дансны мэдээлэл .....	9
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан.....	11
3.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан .....	11
3.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	12
3.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	13
3.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	15
3.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	15
3.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийг тайлан .....	16



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

64101 Баянхонгор аймаг,  
Баянхонгор сум, Номгон баг  
Утас, факс 7044 2584  
E-mail: bayankhongor@audit.gov.mn

2020.02.27 № 1/300

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г Аудитын гэрчилгээ Г

Г БАЯНХОНГОР АЙМГИЙН Г  
ХҮҮХДИЙН ТЭМҮЖИН ТЕАТРЫН  
ДАРГА Б.ГАНЧИМЭГ ТАНАА Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор аймгийн Хүүхдийн Тэмүжин театрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Хязгаарлалттай санал дүгнэлт**

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Баянхонгор аймгийн Хүүхдийн Тэмүжин театрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймгийн Хүүхдийн Тэмүжин театрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус салбарт мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Аудитын гол асуудал**

Тэмүжин хүүхдийн театр нь батлагдсан орон тоо 20 байхаас 26 орон тойгоор

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

005020262

ажилласан ба Аймгийн Засаг даргын 2019.12.26-ны өдрийн А/625 тоот захирамжаар цалингийн зардалд 13397,4 мянган төгрөгийн төсвийг нэмж тодотгосон байхад НДШ 4983.2 мянган төгрөгийн өглөгтэй гарч батлагдсан төсвийг хэтрүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь "Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох", 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.


Энэ нь "Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх" Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

## 2.1. Оршил

Баянхонгор аймгийн Хүүхдийн Тэмүжин театрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Б.Ганчимэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

## 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020.02.15-наас 2020.02.18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020.02.27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор М.Алтантуяа хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор аймгийн Хүүхдийн Тэмүжин театрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020.01.22-ны өдрийн 13 тоот бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

## 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

#### 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Тус байгууллага нь “Мэргэжлийн чадварлаг боловсон хүчинтэй, чанартай үйлчилгээ таатай орчин технологийн шинэчлэлд тулгуурлаж үзэгчид, суралцагч хүүхдийн эрэлт хэрэгцээг хангаж хүүхдийн авьяас чадварыг нээн хөгжүүлэх, мэргэжлийн чиг баримжаа олгож, тэдэнд урлагийн боловсролоор дамжуулан хүүхдийн бахархалт бүтээлийг болгох, орчин үеийн болон сонгодог ардын өв соёл, биет болон биет бус өвийг сэргээн өвлүүлэх, уран бүтээлийг нийтэд түгээн дэлгэрүүлэх замаар нийгмийн оюун санааны хөгжилд бодитойгоор хувь нэмрээ оруулах” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт ороогүй байна.

Баянхонгор аймгийн Хүүхдийн Тэмүжин театрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Соёлын тухай хууль

#### 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Баянхонгор аймгийн Хүүхдийн Тэмүжин театрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянхонгор аймгийн Хүүхдийн Тэмүжин театр нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Acoulas” программ хангамж ашигладаг байна.

Баянхонгор аймгийн Хүүхдийн Тэмүжин театр нь төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна.

#### 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 31 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 25 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр БСУГ-ын 2019 оны 3 дугаар улирлын санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг "их" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 190512,5 мянган төгрөгөөс тооцон 3810,3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 8462,9 мянган төгрөгөөр тооцсон.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баянхонгор аймгийн Хүүхдийн Тэмүжин театрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 184,5 мянган төгрөгөөр буюу 0.001 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материалын данс байна.

### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	-
Авлага	16.1	427.1	411.0
Урьдчилгаа			
Бараа материал	82,970.1	90,131.5	7,161.4
Үндсэн хөрөнгө	221,167.4	195,444.4	(25,723.0)
Хуримтлагдсан элэгдэл	(190,421.3)	(172,086.3)	18,335.0
<b>Нийт хөрөнгө</b>	<b>113,732.3</b>	<b>113,916.8</b>	<b>184.5</b>
Өр төлбөр	417.4	5,463.6	5,046.1
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	113,314.9	108,453.2	(4,861.7)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>113,732.3</b>	<b>113,916.8</b>	<b>184.5</b>

Бараа материалын данс 7161,4 мянган төгрөгөөр өссөн нь бусад материал 7161,4 мянган төгрөгөөр өссөн.

Үндсэн хөрөнгө 25723,0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант төсвийн хөрөнгөөр 5246,8 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан ба Баянхонгор аймгийн ИТХ-ыг Тэргүүлэгчдийн 2019 оны 12-р сарын 25-ны өдрийн 129 –р тогтоолыг үндэслэн 30969,8 мянган төгрөгийг хөрөнгө акталан байна.

Нийт өглөг 5463,6 мянган төгрөг ба үүнээс НДШ –ийн өр 4570,6 мянга, ажиллагсдад өгөх өглөг 730,1 мянга /аудитаар залруулсан/, тээвэр шатахууны өглөг 8,4 мянган төгрөг байна.

Засгийн газрын оролцоо данс тайлант үеийн үр дүнгийн өөрчлөлтөөр 4861,7 мянган төгрөгөөр буурсан байна.

#### 2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант жилд 366369,0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 366212,7 мянган төгрөг зарцуулж 6,3 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн. Батлагдсан орон тоо 20 байхаас 26 орон тойгоор ажилласан.

Нэмэлт санхүүжилт: Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд өөрийн орлого 15265,7 мянга, Швецарын хөгжлийн агентлагаас 16800,0 мянга, Театр хүүхдийн ирээдүй төсөлд БСШУС яамнаас 15000,0 мянга, АЗДТГ-аас 5000,0 мянга нийт 52065,7 мянган төгрөг орсноос өөрийн орлогоос 365,2 мянга, Швецарын хөглийн агентлагт 3244,0 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлж 48456,5 мянган төгрөгийг төсөл тус бүрд зориулалтын дагуу зарцуулсан байна.

#### 2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 7 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 1 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 25 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 2 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитаар дараах 10563.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 4983.2 мянган төгрөгийн алдаанд зөвлөмж хүргүүлж, 5579.8 мянган төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулав. Үүнд:

1. 2019 оны 8-р сард 3587,9 мянган төгрөгийн цалингийн өглөг цалингийн сан хүрээгүйтэй холбоотойгоор үүссэн ба 9-р сард тус мөнгийг олгохдоо тооцсон цалин дээр нэмж тооцон 317,5 мянган төгрөгийн ХХОАТ болон 412,6 мянган төгрөгийн НДШ-ийг давхардуулан суутгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4-т "үнэн зөв байх" 14.4.2-т "санхүүгийн тайланд бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг бүртгэнэ" гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулав.

2. 2019 оны 5 сарын халаалтын төлбөр 4848,8 мянган төгрөгийг өмнөх оны халаалтын өглөг 417,4 мянган төгрөгтэй хамт шилжүүлсэн бөгөөд нягтлан бодох бүртгэлд халаалтын өглөг үүсгэлгүй өмнөх оны өглөгөөс шууд хаасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 14 дүгээр зүйлийн 14.4.2-т "санхүүгийн тайланд бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг бүртгэнэ" гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулав.

#### 2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Байхгүй.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Баянхонгор аймгийн Хүүхдийн Тэмүжин театр нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 94 мэдээллийг хугацаанд нь, 54 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Үүнд : Тухай бүрд оруулах 8 мэдээ, сар бүр оруулах 3 мэдээ, улирал бүр оруулах 1 мэдээ, бүтэн жилээр оруулах 3 мэдээ нийт 15 мэдээлэлд засвар хийгдсэн.

2019 оны 8 сарын тухай бүр оруулах 8 мэдээ, сар бүр оруулах 3 мэдээг ээлжийн амралттай байсаны уламаас 11 мэдээг хугацаа хоцроож мэдээлсэн.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	8	11	4	4	3
2	Хагас жил	1	4	3	1	-
3	Улирал бүр	1	4	3	1	-
4	Сар бүр	3	36	24	12	-
	Тухай бүр	8	96	60	36	-
	Нийт	21	151	94	54	3

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж өгөгдөөгүй болно.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянхонгор аймгийн Хүүхдийн Тэмүжин театрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

**“Хязгаарлалттай” дүгнэлт**

Баянхонгор аймгийн Хүүхдийн Тэмүжин театрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илрүүлсэн залруулагдаагүй буруу илэрхийллийн санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөө эс тооцвол 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 заалт, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

## Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### 1. Цалингийн данстай холбоотой асуудал

#### 1.1. Илрүүлэлт:

Баянхонгор аймгийн Хүүхдийн Тэмүжин хүүхдийн театр нь батлагдсан орон тоо 20 байхаас 26 орон тойгоор ажилласан ба Аймгийн Засаг даргын 2019.12.26-ны өдрийн А/625 тоот захирамжаар цалингийн зардалд 13397,4 мянган төгрөгийн төсвийг нэмж тодотгосон байхад НДШ 4983,2 мянган төгрөгийн өглөгтэй гарч батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь тохиолдсон байх, үнэн зөв байх аудитын батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 16.5.3-т “батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох”, 16.5.5-т “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” заалтын тус тус зөрчсөн байна.

#### 1.1.2. Эрсдэл:

Цалингийн зардал, НДШ, ХХОАТ тооцоолол буруу хийгдэх, батлагдсан төсөв хэтрүүлэн зарцуулах

#### 1.1.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 16.5.3, 16.5.5 дэх заалтыг хэрэгжүүлэн өглөг, авлага үүсгэхгүй, орон тоонд дүн шинжилгээ хийж зөв төлөвлөж, батлагдсан орон тоог мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд зарлага гарган ажиллаж төсвийг зориулалтын дагуу зарцуулах.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

3.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>82,986,239.00</b>	<b>90,558,627.00</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	16,145.00	427,133.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	16,145.00	427,133.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	82,970,094.00	90,131,494.00
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	6,955,690.00	6,955,690.00
35110	Тусгай зориулалттай материал	6,955,690.00	6,955,690.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	76,014,404.00	83,175,804.00
35410	Бичиг хэргийн материал	185,100.00	185,100.00
35420	Аж ахуйн материал	5,378,100.00	5,378,100.00
35450	Барилгын засварын материал	14,860.00	14,860.00
35470	Бусад хангамжийн материал	70,436,344.00	77,597,744.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>30,746,108.64</b>	<b>23,358,170.84</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	30,746,108.64	23,358,170.84
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	26,985,008.64	19,597,070.84
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	103,648,631.00	88,847,451.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-101,418,928.01	-84,770,250.83
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	109,988,196.00	99,296,396.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-87,391,115.16	-85,603,250.14
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,824,500.00	2,474,500.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-861,275.19	-1,162,775.19
39217	Ном	195,000.00	515,000.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	3,761,100.00	3,761,100.00
39301	Програм хангамж	750,000.00	550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-750,000.00	-550,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	3,761,100.00	3,761,100.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>113,732,347.64</b>	<b>113,916,797.84</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>417,440.00</b>	<b>5,463,557.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	417,440.00	5,463,557.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	417,440.00	5,463,557.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	5,300,712.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	417,440.00	8,460.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	00.00	154,385.00
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	154,385.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>113,314,907.64</b>	<b>108,453,240.84</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	113,314,907.64	108,453,240.84
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	137,949,437.69	137,949,437.69
51101	Өмч: - төрийн	137,949,437.69	137,949,437.69
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	-47,735,891.05	-52,597,557.85
51210	Өмнөх үеийн үр дүн	-47,735,891.05	-47,735,891.05
51220	Тайланг үеийн үр дүн	00.00	-4,861,666.80
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	23,101,361.00	23,101,361.00
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>113,732,347.64</b>	<b>113,916,797.84</b>

3.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>321,936,108.00</b>	<b>418,284,700.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>25,740,000.00</b>	<b>00.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	25,740,000.00	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	25,740,000.00	00.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	25,740,000.00	00.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>9,183,908.00</b>	<b>418,284,700.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	287,012,200.00	00.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	8,000,000.00	52,065,700.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	16,800,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,000,000.00	20,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	15,265,700.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	00.00	366,219,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	366,219,000.00
1340	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	1,183,908.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,183,908.00	00.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>322,882,161.37</b>	<b>421,642,837.42</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>322,882,161.37</b>	<b>421,642,837.42</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	319,833,152.27	417,527,352.42
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	177,726,174.86	219,257,189.00
210101	Үндсэн цалин	177,726,174.86	219,257,189.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шямтгэл</b>	21,550,109.04	27,463,835.00
210201	Тэтгэврийн даатгал	20,928,414.04	27,463,835.00
210202	Тэтгэмжийн даатгал	155,424.00	00.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	124,339.00	00.00
210204	Ажилгүйдлийн даатгал	31,085.00	00.00
210205	Эрүүл мэндийн даатгал	310,847.00	00.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	79,217,990.00	78,590,101.00
210301	Гэрэл, цахилгаан	2,150,668.00	2,409,305.00
210302	Түлш, халаалт	70,464,250.00	69,557,180.00
210303	Цэвэр, бохир ус	6,603,072.00	6,623,616.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3,277,575.00	4,723,219.00
210401	Бичиг хэрэг	879,569.00	1,095,530.00
210402	Тээвэр, шатахуун	1,034,450.00	2,402,230.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	438,306.00	411,734.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	260,000.00	250,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх ахуйн эд зүйлс	665,250.00	563,725.00
2105	<b>Нормативт зардал</b>	520,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	520,000.00	00.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,341,570.00	1,236,400.00
210601	Багаж, техник хэрэгсэл	00.00	100,000.00
210604	Урсгал засвар	1,341,570.00	1,136,400.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	2,946,000.00	2,648,400.00
210702	Дотоод албан томилолт	2,946,000.00	2,648,400.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	24,043,275.00	72,477,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	23,743,275.00	71,961,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	300,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	215,200.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	9,210,458.37	11,131,208.42
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хөрогдол	9,210,458.37	11,131,208.42

**Баянхонгор аймгийн Хүүхдийн Тэмүжин театрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,049,009.10	4,115,485.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,498,908.00	500,000.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	1,183,908.00	00.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,315,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	550,101.10	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	550,101.10	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	3,615,485.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	6,285.00
213405	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	3,609,200.00
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-946,053.37</b>	<b>-3,358,137.42</b>
225	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	00.00	1,503,529.38
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	1,503,529.38
4	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	00.00	-1,503,529.38
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-946,053.37</b>	<b>-4,861,666.80</b>

**3.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>321,936,108.00</b>	<b>418,284,700.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>25,740,000.00</b>	<b>00.00</b>
120	Нийтлэг татварын бус орлого	25,740,000.00	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	25,740,000.00	00.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	25,740,000.00	00.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>296,196,108.00</b>	<b>418,284,700.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	287,012,200.00	00.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>8,000,000.00</b>	<b>52,065,700.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	16,800,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,000,000.00	20,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	15,265,700.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>00.00</b>	<b>366,219,000.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	366,219,000.00
1340	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>1,183,908.00</b>	<b>00.00</b>
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,183,908.00	00.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>321,936,108.00</b>	<b>413,037,900.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>321,936,108.00</b>	<b>413,037,900.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>319,652,098.90</b>	<b>408,922,415.00</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>177,637,258.86</b>	<b>217,063,000.00</b>
210101	Үндсэн цалин	177,637,258.86	214,161,085.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	2,125,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	776,915.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>21,463,170.04</b>	<b>24,768,300.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	18,426,501.04	16,842,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	769,027.00	1,981,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	345,076.00	1,585,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	167,609.00	396,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,754,957.00	3,962,900.00

**Баянхонгор аймгийн Хүүхдийн Тэмүжин театрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	78,809,000.00	78,999,081.00
210301	Гэрэл, цахилгаан	2,150,668.00	2,409,305.00
210302	Түлш, халаалт	70,055,260.00	69,966,160.00
210303	Цэвэр, бохир ус	6,603,072.00	6,623,616.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3,348,100.00	4,568,834.00
210401	Бичиг хэрэг	888,193.00	1,034,100.00
210402	Тээвэр, шатахуун	1,028,851.00	2,403,000.00
210403	Шуудан, холбоо, инженерийн төлбөр	460,306.00	411,734.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	260,000.00	180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	710,750.00	540,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	520,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	520,000.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,902,570.00	2,099,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	100,000.00
210604	Урсгал засвар	1,902,570.00	1,999,900.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	2,672,000.00	2,648,400.00
210702	Дотоод албан томилолт	2,672,000.00	2,648,400.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	33,300,000.00	78,774,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	33,000,000.00	78,209,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	300,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	265,200.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,284,009.10</b>	<b>4,115,485.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,733,908.00	500,000.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	1,183,908.00	00.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	550,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	500,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	550,101.10	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	550,101.10	00.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	00.00	3,615,485.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	6,285.00
213405	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	3,609,200.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>00.00</b>	<b>5,246,800.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>00.00</b>	<b>5,246,800.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>00.00</b>	<b>5,246,800.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	00.00	5,246,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	5,246,800.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>00.00</b>	<b>-5,246,800.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	00.00	00.00
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	00.00
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	00.00

3.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	137,949,437.69	23,101,361.00	-46,789,837.68	114,260,961.01
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	137,949,437.69	23,101,361.00	-46,789,837.68	114,260,961.01
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайланг үеийн үр дүн	00.00	00.00	-946,053.37	-946,053.37
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	137,949,437.69	23,101,361.00	-47,735,891.05	113,314,907.64
D01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	137,949,437.69	23,101,361.00	-47,735,891.05	113,314,907.64
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	137,949,437.69	23,101,361.00	-47,735,891.05	113,314,907.64
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валогын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайланг үеийн үр дүн	00.00	00.00	-4,861,666.80	-4,861,666.80
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	137,949,437.69	23,101,361.00	-52,597,557.85	108,453,240.84

3.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	366,369,000.00	366,212,715.00
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	366,369,000.00	366,212,715.00
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	365,869,000.00	365,712,715.00
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	217,063,000.00	217,063,000.00
210101	Үндсэн цалин	171,072,400.00	214,161,085.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,120,000.00	2,125,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	30,870,600.00	776,915.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	24,768,300.00	24,768,300.00
210201	Тэтгэврийн даатгал	24,768,300.00	16,842,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	1,981,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	1,585,200.00
210204	Ажил үйлдлийн даатгал	00.00	396,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	3,962,900.00
2103	<b>Байр ашиг, талтгай холбоотой тогтмол зардал</b>	78,999,300.00	78,999,081.00
210301	Гэрэл, цахилгаан	2,409,400.00	2,409,305.00
210302	Түлш, халаалт	69,966,200.00	69,966,160.00
210303	Цэвэр, бөхир ус	6,623,700.00	6,623,616.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	4,701,200.00	4,568,834.00
210401	Бичиг хэрэг	1,044,200.00	1,034,100.00
210402	Тээвэр, шатахуун	2,553,000.00	2,403,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	384,000.00	411,734.00
210405	Хог хаягдал зайлуулах хортон мэрэгчдийн устгал, ариутгал	180,000.00	180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх ахуйн эд зүйлс	540,000.00	540,000.00

**Баянхонгор аймгийн Хүүхдийн Тэмүжин театрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,100,000.00	2,099,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	100,000.00	100,000.00
210604	Урсгал засвар	2,000,000.00	1,999,900.00
2107	Томилолт, зочны зардал	2,672,000.00	2,648,400.00
210702	Дотоод албан томилолт	2,672,000.00	2,648,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	35,565,200.00	35,565,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	35,000,000.00	35,000,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	300,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	265,200.00	265,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	500000.00	500000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	500,000.00	500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	500,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>366,369,000.00</b>	<b>366,212,715.00</b>
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>366,369,000.00</b>	<b>366,212,715.00</b>
132001	Орон нутгийн төсвөөс	366,369,000.00	366,212,715.00
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>20.00</b>	<b>26.00</b>
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	15.00	18.00
620003	Үйлчлэх ажилтан	04.00	07.00
65	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>20.00</b>	<b>26.00</b>
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	13.00	18.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	07.00	08.00

3.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийг тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>48,456,500.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>48,456,500.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		48,456,500.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		48,456,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		48,456,500.00
IV	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		

САНХҮҮГИЙН ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

ОГНОО: 2020.02.27

ХЯНАСАН

АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЭНЯМ

ОГНОО:2020.02.27

ТАЙЛАН БИЧСЭН АУДИТОР

М.АЛТАНТУЯА

ОГНОО :2020.02.27